



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/090/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.25 № 296

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- ✓ Тайлант онд 6,026.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцоолж тайланд тусгасан.
- ✓ Бараа материал зарлагдахдаа 5,454.0 мянган төгрөгийн материалыг зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн бүртгэсэн.
- ✓ Бараа материалын дансанд үлдэгдэлтэй 1,000.0 мянган төгрөгийн материалыг урсгал засварын зардалд бүртгэсэн.
- ✓ Цалингийн зардлыг 2,267.3 мянган төгрөгөөр илүү тооцоолж тайланд тусгасан.
- ✓ Ээлжийн амралттай ажилтанд 201.8 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон, ээлжийн амралт биеэр эдлээгүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нөхөн олгохдоо 2.3 сая төгрөгөөр илүү тооцон олгосон нийт 17,251.3 мянган төгрөгийн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудад нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага нь тайланд онд улсын төсвөөс 184,887.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 11,661.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 160,354.5 мянган төгрөг зарцуулж, 1,610.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, улсын төсвийн санхүүжилтийн харилцах дансанд 73,436.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг тухай бүр үнэн зөв хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад анхаарч ажиллах шаардлагатай.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17,251.3 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 12,481.3 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 2,502.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,267.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Бусад асуудал

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 65 арга хэмжээ тусгагдаж биелэлт дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,136,587.28	96,321,725.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	38,852,221.88	73,436,810.45
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	38,852,221.88	73,436,810.45
3121	Төгрөг	38,852,221.88	73,436,810.45
31211	Төрийн сангийн харилцах	38,852,221.88	73,436,810.45
33	АВЛАГА	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	22,284,365.40	22,884,915.40
351	Түүхий эд материал	895,000.00	895,000.00
35110	Тусгай зориулалттай материал	895,000.00	895,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	21,389,365.40	21,989,915.40
35410	Бичиг хэргийн материал	736,900.00	555,700.00
35420	Ажахуйн материал	13,095,160.00	14,545,160.00
35440	Түлш, шатах тослох материал	1,350,000.00	900,000.00
35460	Хүнсний материал	218,250.00	-
35470	Бусад хангамжийн материал	5,989,055.40	5,989,055.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	132,976,242.37	121,617,414.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	132,976,242.37	121,617,414.20
392	Биет хөрөнгө	129,665,742.36	118,349,414.20
39201	Барилга, байгууламж орон сууц	132,926,198.00	132,926,198.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,364,373.76)	(24,143,773.68)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	20,574,642.04	8,517,975.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,434,899.21)	(4,141,497.47)
39207	Тавилга, ажахуйн эд хогшил	6,871,621.48	2,229,978.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,269,317.57)	(1,867,804.19)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,039,586.40	10,152,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,898,819.88)	(6,544,766.82)
39217	Ном	1,221,104.86	1,221,104.86
393	Биет бус хөрөнгө	3,310,500.01	3,268,000.00
39301	Програм хангамж	780,000.00	780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(737,499.99)	(780,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,268,000.00	3,268,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	194,112,829.65	217,939,140.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
422	Урт хугацаат зээл	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	194,112,829.65	217,939,140.05
51	Засгийн газрын хувь оролцоо	194,112,829.65	217,939,140.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нут	9,654,023.00	9,654,023.00
51101	Өмч: - төрийн	9,654,023.00	9,654,023.00
512	Хуримтлагдсан үр дүн	166,053,952.55	189,880,262.95
51210	Өмнөх үеийн үр дүн	166,053,952.55	165,109,957.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	24,770,305.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,404,854.10	18,404,854.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	194,112,829.65	217,939,140.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	138,001,880.00	196,549,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,953,580.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	2,953,580.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,953,580.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,953,580.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,048,300.00	196,549,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	124,262,600.00	184,887,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	124,262,600.00	184,887,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,785,700.00	11,661,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,785,700.00	11,661,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	108,521,674.88	171,778,794.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,521,674.88	171,778,794.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,391,813.50	170,168,757.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,633,466.70	117,530,725.05
210101	Үндсэн цалин	56,961,229.13	86,795,284.05
210102	Нэмэгдэл	5,944,439.57	30,735,441.00
210104	Урамшуулал	2,727,798.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,603,355.27	14,415,886.38
210201	Тэтгэврийн даатгал	4,570,904.06	9,950,790.51
210202	Тэтгэмжийн даатгал	803,111.26	1,140,914.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	612,226.29	821,640.44
210204	Ажилгүйдлийн даатгал	214,331.13	590,144.92
210205	Эрүүл мэндийн даатгал	1,402,782.53	1,912,396.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,805,838.62	8,501,363.64
210301	Гэрэл, цахилгаан	2,086,838.62	1,766,363.64
210302	Түлш, халаалт	6,719,000.00	6,735,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,337,500.00	-
210401	Бичиг хэрэг	1,320,500.00	-
210407	Ажахуйн материал худалдан авах зардал	17,000.00	-
2105	Нормативт зардал	10,222,910.00	10,466,700.00
210502	Хоол, хүнс	10,222,910.00	10,466,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	460,000.00	110,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	154,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	306,000.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,828,742.91	18,144,082.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,431,000.00	7,133,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	595,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,397,742.91	10,414,832.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,861.38	1,610,036.36
2134	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,861.38	1,610,036.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,861.38	1,610,036.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	29,480,205.12	24,770,305.79
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	29,480,205.12	24,770,305.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	135,048,300.00	196,549,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,048,300.00	196,549,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	124,262,600.00	184,887,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	124,262,600.00	184,887,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,785,700.00	11,661,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуул	10,785,700.00	11,661,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	99,363,214.97	161,964,511.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,363,214.97	161,964,511.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,233,353.59	160,354,475.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,290,999.70	116,716,796.05
210101	Үндсэн цалин	56,343,973.70	86,252,416.00
210102	Нэмэгдэл	5,877,000.31	24,498,542.05
210104	Урамшуулал	3,070,025.69	5,965,838.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,603,355.27	15,229,815.38
210201	Тэтгэврийн даатгал	4,965,017.28	10,764,719.51
210202	Тэтгэмжийн даатгал	715,856.58	1,140,914.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	569,327.81	821,640.44
210204	Ажилгүйдлийн даатгал	187,967.65	590,144.92
210205	Эрүүл мэндийн даатгал	1,165,185.95	1,912,396.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,155,838.62	8,051,363.64
210301	Гэрэл, цахилгаан	2,086,838.62	1,766,363.64
210302	Түлш, халаалт	6,900,000.00	6,285,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,169,000.00	-
2105	Нормативт зардал	9,491,160.00	10,222,200.00
210502	Хоол, хүнс	9,491,160.00	10,222,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	306,000.00	705,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	306,000.00	705,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,886,000.00	7,429,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,969,000.00	5,543,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	917,000.00	1,886,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,861.38	1,610,036.36
2134	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	129,861.38	1,610,036.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,861.38	1,610,036.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	35,685,085.03	34,584,588.57
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
14	Бусад эх үүсвэр	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	35,685,085.03	34,584,588.57
9	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,852,221.88	38,852,221.88
10	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,852,221.88	73,436,810.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	166,053,952.55	194,112,829.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	166,053,952.55	194,112,829.65
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	166,053,952.55	194,112,829.65
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	166,053,952.55	194,112,829.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(943,995.39)	(943,995.39)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	165,109,957.16	193,168,834.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	24,770,305.79	24,770,305.79
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	189,880,262.95	217,939,140.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,400,200.00	160,354,475.07	75,045,724.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,400,200.00	160,354,475.07	75,045,724.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,400,200.00	160,354,475.07	75,045,724.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,756,700.00	116,510,576.05	63,246,123.95
210101	Үндсэн цалин	122,606,100.00	86,252,416.00	36,353,684.00
210102	Нэмэгдэл	56,573,200.00	24,292,322.05	32,280,877.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-
210104	Урамшуулал	577,400.00	5,965,838.00	(5,388,438.00)
210105	Гэрээт ажлын хөлс			-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,050,900.00	15,229,815.38	5,821,084.62
210201	Тэтгэврийн даатгал	14,315,000.00	10,764,719.51	3,550,280.49
210202	Тэтгэмжийн даатгал	1,683,700.00	1,140,914.03	542,785.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	842,000.00	821,640.44	20,359.56
210204	Ажилгүйдлийн даатгал	842,000.00	590,144.92	251,855.08
210205	Эрүүл мэндийн даатгал	3,368,200.00	1,912,396.48	1,455,803.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,661,400.00	8,051,363.64	1,610,036.36
210301	Гэрэл, цахилгаан	2,505,100.00	1,766,363.64	738,736.36
210302	Түлш, халаалт	6,285,700.00	6,285,000.00	700.00
210303	Цэвэр, бохир ус	870,600.00	-	870,600.00
210304	Байрны түрээс			-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			-
2105	Нормативт зардал	13,678,700.00	10,222,200.00	3,456,500.00
210502	Хоол, хүнс	13,678,700.00	10,222,200.00	3,456,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл			-
210602	Тавилга			-
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	-	-
210702	Дотоод албан томилолт			-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	705,000.00	705,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	705,000.00	705,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,547,500.00	7,635,520.00	911,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,653,900.00	5,749,520.00	904,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,893,600.00	1,886,000.00	7,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	235,400,200.00	194,939,063.64	40,461,136.36
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	184,887,700.00	184,887,700.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	184,887,700.00	184,887,700.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,661,400.00	10,051,363.64	1,610,036.36
132001	Орон нутгийн төсвөөс	11,661,400.00	10,051,363.64	1,610,036.36
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	38,851,100.00	-	38,851,100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,851,100.00		38,851,100.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		38,852,221.88	(38,852,221.88)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		73,436,810.45	(73,436,810.45)

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 12,481.3 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 6,026.4 мянган төгрөгөөр дутуу тооцон санхүүгийн тайланд тусгасан.
2. 5,248.7 мянган төгрөгийн бараа материалын зарлагыг зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн бүртгэсэн.
3. Бараа материалын дансанд үлдэгдэлтэй 1,000.0 мянган төгрөгийн материалыг урсгал засварын зардалд бүртгэсэн.
4. Хог хаягдлын хураамж төлсөн гүйлгээг зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн цалингийн зардалд бүртгэсэн.

Аудитаар нийт 4,770.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс, 2,502.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,267.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Ээлжийн амралттай ажилтанд 201.8 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон, ээлжийн амралт биеэр эдлээгүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нөхөн олгохдоо 2,300.9 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон.

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацааны цалингийн зардлыг 2,267.3 мянган төгрөгөөр илүү тооцож тайланд тусгасан.

5.3 Зөвлөмж

Байхгүй.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлийн зардал дутуу тооцсон	1	6,026.4			1	6,026.4	1	6,026.4				
Зардлын эдийн засгийн ангилал зөрүүлсэн	1	5,248.7			1	5,248.7	1	5,248.7				
Үлдэгдэлтэй бараа материалыг зарлагдсан	1	1,000.0			1	1,000.0	1	1,000.0				
Зардлын эдийн засгийн ангилал зөрүүлсэн	1	206.2			1	206.2	1	206.2				
Дүн	4	12,481.3			4	12,481.3	4	12,481.3				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлыг буруу илэрхийлсэн	1	2,267.3			1	2,267.3						
Ээлжийн амралтыг илүү тооцон олгосон, ээлжийн амралттай давхардуулан цалин олгосон	1	2,502.7	1	2,502.7								
Дүн	2	4,770.0	1	2,502.7	1	2,267.3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0,00	0	0,00	0	0,00	0	0,00

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 102-ХЭА-2025/090/НА-СТА-ТШЗ
А 2371281 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг 2,267.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлж, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

- Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтын дагуу хөтөлдөггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэгийн эрхлэгч М.Хүүхнээ, нягтлан бодогч М.Хангай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР

232504102



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 92-ХЭА-2025/090/НА-СТА-ТШЗ
А 2371281
Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 2 ажилтны ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 2,502.7 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү тооцож олгосон цалингийн 2,502.7 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цэцэрлэгийн эрхлэгч М.Хүүхнээ, нягтлан бодогч М.Хангай нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Н.ХЭРЛЭНБАЯР